

үзэх жишээтэй.¹⁰ Юутай ч атугай олон нийтийн санаа бодол гадаад бодлогын шийдвэр гаргах үйл явцад нөлөөлөгч чухал хүчин зүйл гэдгийг тэмдэглэх учиртай.

Гадаад бодлогын шийдвэр гаргах үйл явц зохион байгуулалтын, оюуны гэсэн хоёр хэсгээс бүрдэнэ. Зохион байгуулалтын хэсэгт тухайн улсын үндсэн хуулиар хуульчилсан төрийн тогтолцоо багтана. Гадаад бодлогын аливаа шийдвэр танин мэдэхүүд тулгуурлана. Танин мэдэхүйн үйл явц нь мэдээлэлд, мэдээлэл нь дүн шинжилгээнд тулгуурлах бөгөөд дүн шинжилгээнээс шийдвэрт хүрдэг. Монголын төр, засгийн удирдагчид, дипломатууд шийдвэр гаргах урлагийг хэдийчинээ сайн эзэмшинэ, Монгол улсын сэргэн мандалтад төдий чинээ хэрэгтэй.

1. Гадаад бодлогын шийдвэр гаргах үйл явцыг шинжлэх ухааны бие даасан салбарын хувьд Америкийн эрдэмтэн Р. Снайдер анх 1950-аад оны үед үндэслэжээ. See Richard C. Snyder and others. Foreign policy decision making. New York, The free press, 1962.
2. John L. Sherburne. The role of Outer Mongolia in Sino-Soviet relations and its significance to the USA. USAF. Alabama, 1964, pp. 47, 48.
3. Johan Galtung. A Structural theory of imperialism in the war system. ed. Richard A. Falk and Samuel Kim. West view press (Boulder, Colorado, 1980, pp. 402-447)
4. Hans J. Morgenthau. The future of diplomacy in international politics. ed. , by Robert J. Art and Robert Jervis, pp. 101 — 1 03.
5. Interrelations: Public and foreign policies, ed. R. Terschek and others. pp. 75—78.
6. Reinolds P. A. An introduction to international relations. Schenkman Publishing Company. Inc. Cambridge, Massachusetts, 1971, p. 168.
7. The war system. p. 328.
8. 1950 онд Солонгост цэрэг илгээх шийдвэрийг 14 хүний, 1962 оны карибын хямралын тухай шийдвэрийг 16 хүний бүрэлдэхүүнтэй хэсэг тус тус гаргажээ. See Glenn D. Paige. Comparative case, Analysis of crises decisions: Korea and Cuba in the war system. pp. 514-517.
9. Hans Morgenthau. The future of diplomacy in international politics. p. 107.
10. Reinolds P. A. An Introduction to international relations. p. 176.

ЯПОНЫ ГАДААД БОДЛОГО: ӨЧИГДӨР, ӨНӨӨДӨР

Ц. Батбаяр*

XX зуун төгсгөлдөө дөхөж XXI зуун наашлахын сацуу ерөнхийлөгч Ж. Бушийн 1990 онд анх санааг нь дэвшүүлсэн «дэлхийн шинэ дэг журам» ямар тогтолцоотой байх вэ, үүнд Япон ямар байр эзлэх вэ гэсэн асуулт Азийн олон орны нийслэлд тавигдах боллоо. Япон нь XXI зуун чиглэсэн шинэ нээлттэй бодлого явуулах ёстой гэсэн санал ч гарч байна. Анх 200 гаруй жил түгжигдмэл байсан Японы үүд хаалгыг 1854 онд Америкийн адмирал Перри цэргийн хүчээр нээсэн билээ.

*Дорнодахин, олон улс судлалын хүрээлэнгийн захирал, дэд эрдэмтэн.

Дэлхийн II дайны дараа мөн л Америкийн генерал Макартур Японы цэрэг-санхүүгийн тогтолцоог эвдэж шинэ үеийг нээсэн. Тэгвэл энэ удаад Япон нээлттэй бодлого зарлах аваас гурав дахь нь болох юм.

1945-1952 онд Япон нь Дэлхийн I дайнд ялагдсан орны хувьд гадаад бодлого явуулах эрхгүй, бүхий л гадаад харилцаа нь Токиод байрласан холбоотон гүрнүүдийн Ерөнхий командлалтай (командлагч нь генерал Д. Макартур) харилцаагаар хязгаарлагдаж байв. Энэ хугацаанд Японы цэргийн аж үйлдвэрийг устгах, зайбацу хэмээн санхүүгийн тогтолцоог эвдэх алхмууд хийгдсэн юм. 1947 онд батлагдсан шинэ Үндсэн хуулийн (9 дүгээр заалт) дагуу Япон нь газар, тэнгис, агаарын аливаа зэвсэгт хүчтэй байх, мөн дайн хийх бүрэн эрхээс татгалзсан билээ.

1951 оны 9 дүгээр сард холбоотон гүрнүүд (ЗХУ, Хятад, Энэтхэг болон Бирмийг үл оролцуулан нийтдээ 48 орон) Японтой Сан-Францискогийн энхийн гэрээ байгуулж гарын үсэг зурснаар Японы бүрэн эрхт байдал сэргээгдсэн. Тухайн үед ЗХУ-ын ГЯЯ-ны сайд байсан А. Громыко Сан-Францискод хүрэлцэн очсон боловч энхийн гэрээнд гарын үсэг зураагүй юм. Энэ нь энхийн гэрээтэй нэгэн зэрэг Япон нь АНУ-тай аюулгүйн гэрээ байгуулж, Америкийн цэргийн баазыг нутаг дэвсгэртээ байрлуулж, цөмийн шүхэрт нь дулдуйдах болсныг Зөвлөлтийн удирдлага эсэргүүцсэнтэй холбоотой.

Дэлхийн II дайны дараа Зөвлөлт-Америк, Дорнод-Өрнөдийн хооронд үзэл суртал, ёс суртахууны гүн зөрчил үүсэж «хүйтэн дайн» эхэлсэн билээ. Ингэснээр дэлхий ертөнц үндсэндээ хоёр хэт их гүрэнд тулгуурласан бие биедээ дайсагнагч хоёр эвсэл бүлэгт хуваагдсан юм. Япон нь АНУ-тай аюулгүйн гэрээ байгуулснаар Өрнөдийн бүлэгт багтаж, ЗХУ, БНХАУ-тай сөргөлдөх бодлогод татагдан орсон. Иймээс ч Япон, Тайваны засгийн газрыг хууль ёсны хэмээн хүлээн зөвшөөрч 20 орчим жил БНХАУ-тай албан ёсны харилцаагүй явж иржээ.

1950-аад оны хоёруугаар хагаст олон улсын харилцаанд бий болсон түр намжмал байдал Япон-Зөвлөлтийн хоорондох харилцааг хэвийн болгох асуудлаар хэлэлцээ хийх нөхцөл бүрдүүлэв. Ийнхүү 1956 оны 10-р сард хоёр орон хамтарсан мэдэгдэл гаргаж, дипломат харилцааг сэргээхийн хамт энхийн гэрээ байгуулах асуудлаар хэлэлцээг үргэлжлүүлэхээр шийдсэн юм. Гэвч энхийн гэрээ Курилийн 4 арал буюу япончуудын нэрлэдгээр «умард нутгийн» маргаантай асуудлаас болж өнөөг хүртэл сунжирч иржээ. Японы тал энхийн гэрээ байгуулах урьдчилсан нөхцөл бол газар нутгийн асуудлыг шийдвэрлэх явдал хэмээн үргэлж үзэж ирсэн. Нөгөө талаас 1956 оноос хойших ЗХУ-ын (өнөөгийн Оросын Холбооны улс) байр суурь туйлбартай бус, цагийн аясаар өөрчлөгдөж ирснийг хэлэх хэрэгтэй. Тухайлбал, 1956 оны хэлэлцээрээр Зөвлөлтийн тал хоёр орны хооронд энхийн гэрээ байгуулагдсаны дараа Курилийн маргаантай дөрвөн арлын хоёр нь болох Хабомай, Шикотаныг Японд буцааж өгнө гэсэн амлалт авсан юм. Гэтэл 1960-онд Япон АНУ-тай аюулгүйн гэрээгээ сунгангуут Японд гадаадын цэрэг байрлаж байгаа цагт ямар ч арлыг буцааж өгөх асуудлыг ярихгүй хэмээн мэдэгджээ. 1970-аад оны эхээр Дорнод-Өрнөдийн харилцаа дахин зөөлрөх үест 1973 онд гаргасан Танака-Брежневийн хамтарсан мэдэгдэлд хоёр орны хооронд «Дэлхийн II дайнаас хойш үлдсэн шийдэгдээгүй асуудал» бий гэсэн хэлбэрээр газар нутгийн асуудал байгааг хүлээн зөвшөөрсөн юм. 70-аад оны эцсээр Зөвлөлтийн бодлого эргээд хатуурч ГЯЯ-ны сайд байсан А. Громыко Япон газар нутгийн асуудал дэвшүүлсээр байгаа цагт Японд айлчлахгүй гэсэн мэдэгдэл хийж байв. Харин Э. А. Шевардназе 1985 онд ГЯЯ-ны сайд

болсны дараа Өрнөдийн орнуудаас анх түрүүн Японд айлчилж ямар ч асуудал дэвшүүлсэн авч хэлэлцэхэд бэлэн гэдгээ илэрхийлсэн. 1991 оны 4-р сард хуучин ЗХУ-ын ерөнхийлөгч М.Горбачев Японд айлчлах үеэр хоёр орны хооронд газар нутгийн маргаантай асуудал байгааг албан ёсоор хүлээн зөвшөөрсөн юм. ЗХУ-ын хуульзүйн залгамжлагч Холбоот Орос улс, түүний ерөнхийлөгч Б.Н.Ельцин энэхүү ихээхэн ээдрээтэй газар нутгийн асуудлаар ямар байр суурь баримтлахаас Япон Оросын цаашдын харилцаа ихээхэн шалтгаалах болно.

Өмнөд Солонгостой харилцаагаа хэвийн болгох хэлэлцээг Япон Сан Францискогийн бага хурлын дараахан 1951 оны 10-р сараас эхэлжээ. Гэвч хэд хэдэн хүчин зүйлээс шалтгаалан 50-аад онд эдгээр яриа хэлэлцээ амжилтад хүрээгүй. Үүнд 1910-1945 он хүртэл Солонгосын хойгт явуулж байсан Японы колонийн бодлого, түүний уршигт үр дагавраас ангижрах тийм ч амаргви байв. 1948 онд Солонгосын хойгт хуваагдмал хоёр тусдаа улс байгуулагдаж, НҮБ-аас Өмнөд Солонгосыг хууль ёсны засгийн газар хэмээн тооцох болов. 1950 онд Солонгосын дайн дэгдэхэд Япон, Солонгос дахь НҮБ-ын цэргийн хүчийг дэмжихээ илэрхийлж, ганц Өмнөд Солонгостой харилцах болсон юм. 50-аад онд Өмнөд Солонгосын ерөнхийлөгч байсан Ли Сынман Японыг эсэргүүцэх бодлого баримталж, ялангуяа Солонгосын эрэг хавиар Японы агнуурын онгоц загас агнахыг хориглосон тусгай шугам тогтоож хэлэлцээг мухардмал байдалд оруулж байв

1960 онд Сеүлд төрийн эргэлт гарч генерал Пак Чжонхи ерөнхийлөгч болсноор хоёр орны хэлэлцээ дахин сэргэх нөхцөл бүрэлдэв. 1962 онд Японы ГЯЯ-ны сайд, Өмнөд Солонгосын Тагнуулын Төв Газрын дарга нарын хооронд болсон нууц хэлэлцээр үр дүнтэй болж, Япон нь Сеүлд ихээхэн хэмжээний буцалтгүй тусламж, бага хүүтэй зээллэг олгохоор болов. АНУ ч Япон-Өмнөд Солонгосын харилцааг хэвийн болгохыг ихэд чухалчилж, Өмнөд Солонгосын талд шахалт үзүүлэх болов. АНУ-ын төрийн нарийн бичгийн дарга Дын Раск 1964 оны 1-р сард Сеүлд айлчилж, мөн ондоо Америк-Өмнөд Солонгосын хоёр ч хамтарсан мэдэгдэл гаргаж Япон-Өмнөд Солонгосын харилцааг хэвийн болгохыг чухалчилж байв. 1965 оны 2-р сард Япон-Өмнөд Солонгосын хооронд суурь харилцааны гэрээ байгуулагдсанаар харилцаа бүрэн хэвийн болжээ. 1965 оны гэрээгээр 1910 оноос өмнө Японоос Солонгостой байгуулсан бүх гэрээ, хэлэлцээрийг хүчингүйд тооцов. Мөн Япон НҮБ-ын 195-р тогтоолын дагуу Солонгосын хойг дахь цорын ганц хууль ёсны засгийн газар хэмээн Өмнөд Солонгосыг хүлээн зөвшөөрчээ.

Зүүн Өмнөд Азийн (ЗӨА) орнуудтай Япон юуны өмнө дайны төлбөрийн асуудлыг шийдэх ёстой байв. Анх Бирмтэй 1954 онд, дараа нь мөн ондоо Филиппин, Индонез, Өмнөд Вьетнамтай төлбөрийн асуудлаар гэрээ байгуулжээ. Дэлхийн II дайны үед хуримтлагдсан иений ерийг Тайландад төлөхөөр шийдвэрлэж, дараагаар нь Камбож, Лаостай ч төлбөрийг зохицуулав. Хэдий тийм ч 1960-70-аад онд Япон Азид өөрийн зохих байр сууриа эзлэх, ялангуяа ЗӨА-ийн орнуудын Японы эсрэг хардлага сэрдлэгийг даван туулж, тэдний итгэлийг олж автал ихээхэн хүчин чармайлт гаргах шаардлагатай байв. Энэ зорилгод засгийн газрын шугамаар олгодог, албан ёсны хөгжлийн тусламж хэмээх бага хүүтэй удаан хугацааны иенийн зээллэгийг өргөн ашиглаж ирэв. ЗӨА-ийн таван орон (Тайланд, Индонез, Малайз, Филиппин, Сингапур) бүс нутгийн байгууллага АСЕАН-ыг 1967 онд байгуулж, эдийн засаг, нийгэм, соёлын салбарт хамтын ажиллагаагаа эрчимжүүлэх зорилго тавьжээ. Анх байгуулагдсан цагаас Япон улс энэхүү байгууллагыг ЗӨА-ийн тогтвортой байдлыг хангах чухал хүчин зүйл хэ-

мээн дэмжиж ирэв. Эхэн үедээ АСЕАН болон Японы харилцаа зарим эдийн засгийн асуудал, тухайлбал, Японы нефть зөөгч хөлөг онгоцыг Малаккийн хоолойгоор зорчин өнгөрүүлэх зэргээс шалтгаалан зөрчилтэй байлаа. Гэвч энэ талаар Японы гаргасан хэд хэдэн санаачилгын үр дүнд тус байгууллагатай харьцах харилцаа нааштай эргэжээ. Үүнд Японы ерөнхий сайд Фукудагийн 1978 онд Манил хотод дэвшүүлсэн «Фукудагийн номлол»-ыг дурдаж болох юм. Мөн АСЕАН-ын орнуудын эдийн засгийн таван чухал төслийг хэрэгжүүлэхэд зориулан Япон 1 тэрбум долларын фонд байгуулсан билээ. Японы Засгийн газрын хөгжлийн тусламжийн дийлэнх хэсэг АСЕАН-д ноогдож, түүний дотор Индонез томоохон байр эзэлдэг. Анх Жакартад 1977 онд АСЕАН Японы хооронд чуулга уулзалт болсноос хойш энэ нь жил бүр уламжлал болон зохиогддог болжээ.

Австрали, Канад, Шинэ Зеланд, Мексик зэрэг орон ч түүхий эдийн эх булгийн хувьд Японы гадаад бодлогод чухал байр эзлэх болов. Тиймээс ч «Номхон далайн сав газрын эдийн засгийн хүрээ» гэсэн үзэл баримтлал Японд гараагаа авч (анх Японы профессор Киёши Кожима ийм санал дэвшүүлэв. 1980-аад онд үүнийг тойрсон бодлого идэвхжив.¹

1973 онд газрын тосын хямралаас хойш Ойрх Дорнод, ялангуяа Саудын Араб, Иран, Кувейт, Арабын Нэгдсэн Эмират зэрэг орны ач холбогдол мэдэгдэхүйц ихсэв. Япон зөвхөн хэрэгцээ нь байнга нэмэгдэх газрын тос импортлох төдийгүй, өөрийн нефть боловсруулах үйлдвэрийн тоног төхөөрөмж, бусад бүтээгдэхүүнээ экспортлох ихээхэн сонирхолтой байлаа. Японы Засгийн газрын шугамаар үзүүлэх эдийн засгийн тусламжийн багагүй хэсэг ч Ойрх Дорнодын орнуудад чиглэх болов. Ойрх Дорнодын улс төрийн хямрал, тухайлбал, 1979 оны Ираны хувьсгал мөн 1990-1991 оны Персийн булангийн хямрал аль аль нь Японы дипломат бодлогод ихээхэн нөлөөлөх болсон нь тодорхой.

1972 оны 9-р сард БНХАУ-тай дипломат харилцаа тогтоосон нь Японы гадаад бодлогод нэгэн томоохон үйл явдал болсон юм. Ийм алхам хийх болсон нь Хятадын талаарх АНУ-ын бодлогод гарсан өөрчлөлттэй шууд холбоотой. Америк-Хятадын хооронд хэлэлцээ явагдаж байгаа, дараа жил Никсон Хятадад айлчилна гэсэн 1971 оны 7-р сарын 15-ны АНУ-ын мэдэгдэл Японы Засгийн газрыг үнэнхүү балмагдалд оруулжээ. 20 орчим жил Хятадын талаарх Америкийн бодлогод хөтлөгдөн Тайвантай албан ёсоор харилцаж ирсэн Японы хувьд энэхүү мэдэгдэл Хятадтай харилцах байдлаа цоо шинээр авч үзэхэд хүргэсэн. Ийнхүү 1972 оны 9-р сард Японы ерөнхий сайд Танака Бээжинд айлчилж хоёр орны хооронд дипломат харилцаа тогтоож, өмнө нь 2-р сард зөвхөн Шанхайн Коммюнике гаргахаар хязгаарласан Никсоноос нэг алхам илүү хийсэн байна.²

Өнгөрсөн 20 жилд Япон-Хятадын худалдаа, эдийн засгийн харилцаа өргөжиж нэлээд өндөр төвшинд хүрчээ. Хятадтай хийх худалдаа Японы нийт экспортын 7%, импортын 5% орчмыг эзэлж байна. Харин Японы хувийн жин Хятадын нийт импортын 35%, экспортын 12% орчимд хүрч байна. Нөгөө талаар Хятадаас Японтой хийж байгаа худалдааны алдагдал улам бүр нэмэгдсээр байгааг хэлэх хэрэгтэй. Түүнчлэн 1989 оны байдлаар Хятадын гадаад өрийн нийт хэмжээ 49 тэрбум ам.доллар байхад, гадаад валютын нөөц нь 17,5 тэрбум ам. доллар байв. Өөрөөр хэлбэл, 90-ээд онд Хятад гадаад өр төлбөрийн хүндрэлтэй учирч болзошгүй бөгөөд гадаад өрийн 70% орчмыг Японд төлөх юм.³

90-ээд онд Японы гадаад бодлогод хамгийн их хүчин чармайлт шаардах салбар бол Хятад биш, харин АНУ-тай харилцах асуудал

бололтой. Хүйтэн дайн эцэс болж, «Зөвлөлтийн аюул» замхран арилсаар хоёр орны зөрчлийг зохицуулж байсан механизмыг шинэчлэх шаардлага гарав. Персийн булангийн хямралын үеэр Японы Засгийн газар идэвхгүй байдлыг аялдан дагалдах байр суурь баримталсан нь Америкийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр Японыг шүүмжлэх шалтаг боллоо. Гэвч Япон олон улсын тавцанд ахиухан үүрэг гүйцэтгэж чадах эсэх нь 1945 оноос хойш өнөөг хүртэл явж ирсэн Япон-Америкийн харилцааны мөн чанар хэрхэн өөрчлөгдөхөөс хамаарах болно.

Дэлхийн II дайны дараахан үед АНУ нь Японы нурж сүйдсэн эдийн засгийг сэргээн босгож хөл дээрээ босоход нь тусалсан. Гэвч Европын төвөгтэй байдал АНУ-ын анхаарлыг түлхүү их татаж байсныг тэмдэглэх нь зүйтэй. 1950 онд ЗХУ нь коммунист Хятадтай 30 жилийн хугацаатай найрамдал, харилцан туслалцах гэрээ байгуулсан нь Азийн талаарх АНУ-ын бодлогод Японы стратегийн ач холбогдлыг өндөржүүлэв. Солонгосын дайны турш (1950-1953 он) Америкийн цэргийн захиалга Японы эдийн засгийн чадавхийг эрчимжүүлэх хөшүүрэг болж өгсөн юм. Япон нь АНУ-ын дэмжлэгээр 1955 онд ГАТТ-д, 1956 онд НҮБ-д элсэв.

1960-аад онд Америк-Японы аюулгүй байдлын гэрээ хоёр орны харилцааг тодорхойлох гол хүчин зүйл хэвээр байв. 1960 онд энэхүү гэрээг сунгах үеэр Токиод болсон олон нийтийн өргөн эсэргүүцэл америкчуудад анхны сануулга болжээ. Хэдийгээр 1950-иад оны сүүлчээр Япон нь Азийн нийгэмлэгийн гишүүнээ бататгах, НҮБ-д тулгуурласан дипломат бодлого явуулах, чөлөөт ертөнц дэх байр сууриа бэхжүүлэх гэсэн зарчим тунхагласан боловч АНУ-тай тогтоосон онцгой харилцаа нь 60-аад онд ч хэвээр үргэлжилсэн юм.

1960-аад оны II хагаст Японы эдийн засаг АНУ-ын дараа хоёрт орох болж Америкийн зах зээлд чанар сайтай, харьцангуй хямд бараа таваар гаргаж өрсөлдөх болов. 1969-71 онд хоёр орны хооронд нэхмэлийн салбарт анх үүссэн худалдааны зөрчил гүнзгийрч цаашдаа улам олон салбар хамрах болов. Хэдий тийм ч Америкийн аж үйлдвэр хүчтэй хэвээр, худалдааны зөрчил ноцтой асуудал болж хувираагүй байлаа.

1980-аад онд худалдааны зөрчил гүнзгийрч хямарлын шинж чанартай болов. Япон худалдааны гол өрсөлдөгч болж Вашингтон түүнээс хариу зах зээлээ нээж, худалдааны илүүдлээ багасгахыг шаардах болов. Энэ талаар зарим алхам хийсний дүнд Японы худалдааны илүүдэл 1987 онд 57 тэрбум байснаа 1990 онд 41 тэрбум ам.доллар болж буурчээ. Мөн хоёр орны макро эдийн засгийн зөрчлийг арилгах зорилготой тусгай хэлэлцээр ч 1989—1990 онд явагдав. Нөгөө талаас хоёр орны эдийн засгийн харилцан хамаарал улам бүр гүнзгийрч Вашингтон, Токиогийн аль аль нь үүнийг харгалзахгүй байж чадахгүй боллоо.

90-ээд онд Японы гадаад бодлого байгаль орчныг хамгаалах, олон улсын эдийн засгийн дэг журмыг шинэчлэх зэрэг чиглэлээр идэвхжих нь дамжиггүй. Мөн тэргүүлэх донор орны хувьд Японы өмнө гурав дахь ертөнцийн орны өр зээлийг хөнгөвчлөх, хуучин ЗХУ зэрэг зах зээлд шилжиж буй орнуудад санхүүгийн зохих туслалцаа үзүүлэх, засгийн газрын хөгжлийн тусламжийг оновчтой зарцуулах талаар АНУ, бусад хөгжилтэй орнуудтай хамтран ажиллах зорилт тулгарч байна.

1. Japan Review of International Affairs. vol. 1, N 1, Spring/Summer 1987, p. 12—13. .

2. Japan: The Story of a Nation, by Edwin O. Reischauer, The third Turtle edition, Tokyo, p. 324—325,

3. The China Quarterly. Dec. 1990, № 124, pp. 630, 659.